


Долоо хоног тутмын мэдээ мэдээлэл - Монголын Мянганы сорилтын сан

№2 (12)

2021.03.29

## АНУ-ЫН МЯНГАНЫ СОРИЛТЫН КОРПОРАЦ БОЛОН ЭЛЧИН САЙДЫН ЯАМНААС УСНЫ ҮНЭ ЦЭНЭ, АЧ ХОЛБОГДЛЫН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН ОЙЛГОЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЦУВРАЛ БИЧЛЭГ ХҮРГЭЖ ЭХЭЛЛЭЭ



АНУ-ын Мянганы сорилтын корпорац болон Элчин сайдын яамнаас Дэлхийн усны өдрийг тохиолдуулан усны үнэ, ач холбогдлын талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, усанд хандах хандлагыг өөрчлөх зорилго бүхий цуврал видеог хүргэж эхэллээ. Цувралын эхний бичлэгээр хүрэлцээт цэвэр усны байгаль орчин дахь чухал үүргийн талаар танилцуулсан бөгөөд [энэ холбоосоор орж үзэж](#) болон [татаж авч](#) болохоос гадна Элчин сайдын яамны олон нийтийн сүлжээн дэх хуудсууд ([Facebook](#), [Twitter](#)), Монголын Мянганы сорилтын сангийн [цахим хуудсаас](#) үзэж боломжтой юм. Дэлхийн усны өдрөөр эхэлсэн энэхүү цуврал нь 2021 оны 4 дүгээр сарын 22 буюу Дэлхийн байгаль орчны өдрийг хүртэл үргэлжлэн олон нийтэд нийтэд хүрэх юм. АНУ-ын МСК, Элчин сайдын яам нь Монгол Улсын Засгийн газартай хамтран Улаанбаатар хотын цэвэр усны хангамж хүртээмжийг сайжруулах 350 сая ам.долларын Компакт гэрээг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

[Эх сурвалж: АНУ-ын Элчин сайдын яам](#)

## ШИНЭ ТӨВ ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖ 2024 ОНД АШИГЛАЛТАД ОРНО



2021 оны 3 дугаар сарын 26-ны өдөр Барилга, хот байгуулалтын яамнаас салбарын цаг үеийн асуудлаар мэдээлэл хийлээ. Яамны өгсөн мэдээллээр Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр Дархан-Уул, Архангай, Өвөрхангай, Өмнөговь, Дорноговь, Булган, Хөвсгөл, Дундговь, Хэнтий, Сүхбаатар аймгийн цэвэрлэх байгууламжийн барилга угсралтыг шинэчлэх төслийн явц 80 хувьтай байна. Үүнээс Архангай, Өвөрхангай, Булган аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажил дуусч, үлдсэн зургаан аймгийнхыг энэ онд дуусахаар төлөвлөжээ. Харин Улаанбаатар хотын бохир ус цэвэрлэх байгууламж 2024 онд ашиглалтад орох юм байна. Мөн Бүгд Найрамдах Польш Улсын хөнгөлөлттэй зээлээр Увс, Баян-Өлгий, Дорнод, Завхан, Говьсүмбэр аймгийн төвийн бохир ус цэвэрлэх байгууламжийг барих ажлын сонгон шалгаруулалтыг шинээр зарлаад байгаа аж. Түүнчлэн Ковид-19 цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх Засгийн газрын шийдвэрийн хүрээнд хүрээнд Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлтэй хамтран 2020 оны 12 дугаар сараас 2021 оны 3 дугаар сар хүртэл 740.2 мянган айл өрх, 23.4 мян аж ахуйн нэгж, байгууллагын цэвэр, бохир усны төлбөр нийт 34.6 тэрбум төгрөгийг төрөөс хариуцаж, дэмжлэг үзүүлээд байна.

[Эх сурвалж: БХБЯ](#)

## ОРОН НУТГИЙН СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГ, ДОТУУР БАЙРУУДЫН АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖИЙН АСУУДЛЫГ ШИЙДНЭ



2021 оны 3 дугаар сарын 25-ны өдөр БШУЯ, БОАЖЯ, БХБЯ-ны гурван сайд Улсын Их Хурлын эмэгтэй гишүүдтэй уулзаж сургууль, цэцэрлэгийн нүхэн жорлонг халж, ариун цэврийн байгууламж барих асуудлаар ярилцаж, хэлэлцүүлэг өрнүүлжээ. Төрийн өмчийн сургууль, цэцэрлэг, дотуур байрнуудын модон жорлонг орчин үеийн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар шинэчлэх ажлыг “Эрдэнэт” төрийн өмчит үйлдвэрийн газар нийгмийн хариуцлагын хүрээнд шийдвэрлэх болсон байна. Өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд 21 аймгийн 330 сумын 819 сургууль, цэцэрлэг, дотуур байр модон жорлонтой байгаа бөгөөд үүний долоон сургууль нь Улаанбаатар хотод байна. Нүхэн жорлонг эко ариун цэврийн байгууламжаар шинэчлэхэд тулгардаг асуудлууд болох орон нутгийн усны хүртээмж, цахилгаан эрчим хүч, ашиглалтын зардал, дэд бүтэц зэрэг томоохон асуудлыг хэрхэн шийдвэрлэх тал дээр гишүүд санал солилцож, ярилцжээ. Уулзалтаар хэлэлцүүлсэн асуудлыг гурван яамны хамтарсан ажлын хэсэг өнөөдөр буюу 2021 оны 3 дугаар сарын 29-ний даваа гаригт Намын бүлэгт танилцуулснаар Орон нутагт сургууль, цэцэрлэг, дотуур байрны ариун цэврийн байгууламж барих ажлын технологийн шийдэл, байршлын судалгааны ажлууд эхлэх юм байна.

[Эх сурвалж: БОАЖЯ](#)

## УСНЫ САЛБАРЫН ҮЕ ҮЕИЙН МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ХАРИЛЦАА ХОЛБООГ ИДЭВХЖҮҮЛЖ, МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТ, ЗӨВЛӨГӨӨН ЗОХИОН БАЙГУУЛЖ АЖИЛЛАНА

Дэлхийн усны өдрийг тохиолдуулан Монголын усжуулагчдын холбооны Удирдах зөвлөлийн уулзалт болсон байна. Уулзалтаар тус холбооны Удирдах зөвлөлийн гишүүдийг шинэчилж, Гавьяат, Зөвлөх инженер, Профессор, Доктор, Магистр, Мэргэшсэн инженерийн зэрэг цолтой, төр, сургууль, хувийн хэвшил болон ахмад, дунд, залуу үеийг хамарсан 13 гишүүнтэй байхаар тогтжээ. Мөн уулзалтаар усны салбарын үе үеийн мэргэжилтнүүдийн харилцаа холбоог идэвхжүүлэх, мэдээлэл солилцох, мэргэшүүлэх сургалт, зөвлөгөөн зохион байгуулах, салбарын норм, стандарт шинэчлэл, судалгаа шинжилгээний ажлуудад идэвхтэй оролцож ажиллах, орон нутгийн мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж ажиллах, салбарын хувийн хэвшлийн байгууллага, мэргэжилтнүүдийг дэмжиж ажиллах үндсэн чиглэлүүдэд холбооны үйл ажиллагааг идэвхжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

[Эх сурвалж: Монгол Улсын усны салбар фэйсбүүк хуудас](#)